

НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР

ИХ БАГТААМЖИЙН НИЙТИЙН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ “МЕТРО”-Г БАРИХ  
ТӨСЛИЙН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АЖИЛ ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ТЕНДЕР  
ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ

Тендер  
шалгаруулалтын  
нэр:

Их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл “Метро”-г барих  
төслийн бүтээн байгуулалтын ажил

Тендер  
шалгаруулалтын  
дугаар:

НХААГ/20240101236

Улаанбаатар хот  
2024 он

## I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА А.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1. Тендерийн цар хүрээ**

1.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “Хууль” гэх)-ийн дагуу Өгөгдлийн хүснэгтэд заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон ажил, түүний дагалдах үйлчилгээ (цаашид “ажил” гэх) худалдан авахаар тендер шалгаруулалтыг зохион байгуулна. Тендер шалгаруулалтын нэр болон дугаарыг Өгөгдлийн хүснэгтэд заана.

1.2.Тендер шалгаруулалт багцтай бол энэ тухай мэдээллийг Өгөгдлийн хүснэгтэд заана.

1.3.Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа үед энэ тухай Өгөгдлийн хүснэгтэд заана.
- 2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг**

2.1.Тендер шалгаруулалтын нийт болон багц тус бүрийн санхүүжилтийн эх үүсвэр, батлагдсан төсөвт өртгийг Өгөгдлийн хүснэгтэд тусгана.
- 3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж**

3.1.Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.
- 4. Худалдан авах ажиллагааны цахим систем**

4.1.Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)) /цаашид “цахим систем” гэх/-ээр зохион байгуулна.
- 5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх**

5.1.Захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ.

5.2.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 20<sup>1</sup>, 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй байна.
- 6. Сонирхогч этгээд, оролцогчид тавигдах ерөнхий шаардлага**

6.1.Аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т зааснаар үйлчилгээний хураамж төлснөөр тус тендер шалгаруулалтын сонирхогч этгээд болно.

6.2.Сонирхогч этгээдийн төлсөн үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй.

6.3.Оролцогчтой холбоотойгоор хуулийн 7.1-д заасан

нөхцөл үүсээгүй буюу ерөнхий шаардлагыг хангасан байна.

6.4.Оролцогч хуулийн 6 дугаар зүйлд нийцүүлэн тендер ирүүлнэ.

6.5.Тендер шалгаруулалтад оролцох гадаадын этгээд үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу эцсийн өмчлөгчөөр бүртгэгдсэн этгээдийн мэдээллийг ирүүлнэ.

6.6.Монгол Улсын хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд зааснаар бүртгүүлсэн мэдээлэлд үндэслэнэ.

6.7.Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.

**7. Туслан гүйцэтгэгч, түншлэлд тавигдах шаардлага**

7.1.Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлага хангасан байна.

7.2.Туслан гүйцэтгүүлэх гэрээ хуулийн 6.4-т заасныг зөрчсөн бол захиалагч тухайн туслан гүйцэтгүүлэх гэрээ, туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.

7.3.Түншлэлийн болон туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.

7.4.ТШЗ-ны 7.3-т заасан нь гадаадын этгээд түншлэлийн гишүүн, эсхүл туслан гүйцэтгэгчээр ороход хамаарахгүй.

7.5.Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэгдсэн хугацаа дуусгавар болоогүй бол ерөнхий шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

**9. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах**

7.6.Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах бол энэ тухай хүсэлтийг тендерийн нээлтээс ажлын таваас доошгүй өдрийн өмнө бичгээр захиалагчид гаргаж болно.

7.7.Тодруулга авах хүсэлтийг Өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүлээн авна.

7.8.Тодруулга авах хүсэлтэд үйлчилгээний хураамж төлсөн баримтыг хавсаргана.

7.9.Захиалагч тодруулга авах хүсэлтийн хариуг албан бичгээр үйлдэж, цахим системд нийтэлснээр хүргүүлсэн гэж тооцно.

7.10.Захиалагч тодруулгын үр дүнд тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл ТШЗ-ы 0-д заасныг мөрдөнө.

**11. Тендер шалгаруулалтын баримт**

11.1 Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт

**бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах**

нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

11.2 Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулсан бол түүнийг цахим системд нийтэлснээр хүчинтэйд тооцогдоно.

11.3 Хэрэв тендер нээхээс ажлын таван өдрийн дотор тендер шалгаруулалтын баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг оруулсан бол тендер хүлээн авах эцсийн хугацааг ажлын таваас доошгүй өдөр байхаар тооцож, шаардлагатай хугацаагаар сунгана.

**В. ТЕНДЕР БЭЛТГЭХ**

**12. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл**

12.1 Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.

12.2 Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн хэлийг Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.

12.3 Хэрэв ТШЗ-ны 0-т зааснаар бэлдсэн тохиолдолд тендер шалгаруулалтын баримт бичгийн монгол хэл болон гадаад хэлээр бэлтгэсэн хувилбар хоорондоо зөрвөл монгол хэлээр бэлтгэсэн хувилбарыг баримтална.

12.4 Тендер хянан үзэх, үнэлэхэд захиалагч гадаад хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг үндэслэх ба оролцогч өөрөө, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.

**13. Тендерийн иж бүрдэл**

13.2.6 санал болгож буй ажил ТШЗ-ны 20-д заасан шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг.

13.3 Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.

**16. Ерөнхий шаардлагыг магадлах баримт бичиг**

16.2 Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан, эсхүл оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ:

16.2.1 хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг;

## **Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ**

### **25. Тендер баталгаажуулах, илгээх**

25.3 Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол V бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 25.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.

### **26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа**

26.1 Тендер хүлээн авах эцсийн хугацааг Өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.

26.2 Захиалагч тендерийн нээлтийг цахим системээр Өгөгдлийн хүснэгтэд заасан огноо, цагт зохион байгуулна. Тендерийн нээлтэд оролцогч, эсхүл түүний төлөөлөгч байлцах эрхтэй.

## II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

(Нээлттэй тендер шалгаруулалтын нэгдүгээр үе шатанд оролцогч нь зөвхөн тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтэд шаардсан материалыг ирүүлнэ.)

ТШЗ-ны холбогдох заалт	А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ
ТШЗ 1.1	Захиалагч: Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар
ТШЗ 1.1	Тендер шалгаруулалтын нэр: Их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл “Метро”-г барих төслийн бүтээн байгуулалтын ажил (Улаанбаатар хот) Төсөл, арга хэмжээний дугаар: НХААГ/20240101236
ТШЗ 1.1	Тендер шалгаруулалтын зарлалын дугаар: НХААГ/20240101236/01/01
ТШЗ 1.2	Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b>Багцгүй</b>
ТШЗ 1.3	Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: <b>“Үгүй”</b>
ТШЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт
ТШЗ 2.1	Нийт төсөвт өртөг: <b>4,548,375,000,000 (дөрвөн их наяд таван зуун дөчин найман тэрбум гурван зуун далан таван сая) төгрөг</b> Үүнээс 2024 онд <b>333,000,000,000 (гурван зуун гучин гурван тэрбум) төгрөгийг санхүүжүүлнэ.</b>
<b>Б. АГУУЛГА</b>	
ТШЗ 7.6	<p>Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хаяг:</p> <p>Хүлээн авагчийн нэр: Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар,</p> <p style="text-align: center;">Хаяг: Нийслэлийн Нутгийн захиргааны төв байр, Б блок 7 давхар, 23 дугаар хороо, Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 17100</p> <p>Утасны дугаар: 75757807</p> <p>Цахим шуудангийн хаяг: <a href="mailto:info@ub-procurement.mn">info@ub-procurement.mn</a></p> <p>Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах бол энэ тухай хүсэлтийг тендерийн нээлтээс ажлын таваас доошгүй өдрийн өмнө бичгээр болон тоон гарын үсгээр баталгаажуулан цахимаар захиалагчид гаргаж болно. Тодруулга авах хүсэлтэд үйлчилгээний хураамж төлсөн баримтыг хавсаргана.</p> <p>Захиалагч тодруулга авах хүсэлт хүлээн авснаас хойш тодруулгыг тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын хоёроос доошгүй өдрийн өмнө бичгээр гаргана</p> <p>Захиалагч тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийн хариуг хүсэлт гаргагчийн нэрийг дурдалгүйгээр албан бичгээр гаргаж, түүний хуулбарыг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>) дэх тендерийн баримт бичгийн “тодруулга” хэсэгт нийтэлнэ. Ийнхүү нийтэлсэн даруйд тус тодруулга, нэмэлт мэдээллийг бүх тендер оролцогчдод нэгэн зэрэг хүргүүлсэнд тооцно.</p> <p>Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичгийн салшгүй хэсэг болох тодруулга, нэмэлт, өөрчлөлтийг тендер хүлээж авах эцсийн хугацаа хүртэл шалган нягталж, түүнд нийцүүлэн тендер бэлтгэнэ.</p>

ТШЗ 10.1	Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: Тендер шалгаруулалтын нэгдүгээр үе шатанд “Үгүй”
<b>В. ТЕНДЕР БЭЛТГЭХ</b>	
ТШЗ 12.1	<p>Тендер шалгаруулалтын хэл: <b>Монгол хэл.</b></p> <p>Тендер шалгаруулалтын урилга, тендерийн баримт бичгийг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, тендерт оролцогчдын ирүүлэх тендер Монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг зохих ёсоор орчуулсан баталгаат орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.</p>
ТШЗ 13.2.6	<p><b>Тендер шалгаруулалтын нэгдүгээр үе шатанд санал ирүүлэх сонирхогч этгээд нь батлагдсан техникийн тодорхойлолтод өөрчлөлт оруулах шийдэл, саналыг ирүүлнэ. Тусгайлан өгөх санал, шийдэлгүй тохиолдолд сонгон шалгаруулалтад оролцох сонирхлоо ирүүлж болно.</b></p> <p><b>Захиалагч нэгдүгээр үе шатанд ирүүлсэн техникийн шийдлийг судалж, шаардлагатай бол сонирхогч этгээдээс тодруулга авсны үндсэн дээр тендер шалгаруулалтын баримт бичгийг эцэслэн боловсруулж, тендер шалгаруулалтын урилгыг нэгдүгээр үе шатанд оролцсон этгээдэд хүргүүлнэ.</b></p> <p><b>Нэгдүгээр үе шатанд оролцогчид түншлэлээр оролцох бол түншлэлийн гишүүдийн мэдээллийг ирүүлнэ.</b></p> <p><b>Нээлттэй тендер шалгаруулалтын хоёрдугаар үе шатанд зөвхөн нэгдүгээр үе шатанд оролцсон этгээд болон түншлэлийн гишүүд тендер ирүүлэх эрхтэй. Эхний шатанд оролцсон оролцогчид хоёрдугаар шатны тендер шалгаруулалтад өөр хоорондоо түншлэл, туслан гүйцэтгэгч хэлбэрээр оролцож болно.</b></p> <p><b>Нээлттэй тендер шалгаруулалтын нэгдүгээр үе шат бүрэн дуусмагц хоёрдугаар үе шат эхэлнэ.</b></p>
ТШЗ 16.2.1	<p>Ерөнхий шаардлагыг магадлахад шаардагдах бусад баримт бичиг: “<b>Шаардана</b>”</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Тендерт оролцогч нь үүсгэн байгуулагдсан улсын эрх бүхий байгууллагаас олгосон Улсын бүртгэлийн гэрчилгээ эсхүл түүнтэй дүйцэхүйц баримт бичгийг ирүүлнэ. Тендерт оролцогч хуулийн этгээд нь байгууллагын талаарх танилцуулга ирүүлнэ .</li> <li>2. Тус ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалт нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 33 дугаар зүйлийг үндэслэн Хоёр үе шаттай нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулагдана.</li> </ol>
ТШЗ 24.1	Тендерийн баталгааны дүн: Тендер шалгаруулалтын нэгдүгээр үе шатанд “ <b>Шаардахгүй</b> ”
<b>Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ</b>	
ТШЗ 25.3	<p>Тендер шалгаруулалтад оролцохыг сонирхогч этгээд нь тендерийн материалыг Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> дамжуулан заавал цахимаар илгээнэ. Цахим системээр материал илгээхийн тулд дараах зүйлсийг анхаарна уу. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Өөрийн компанийн нэр дээр Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> системд бүртгэл үүсгэсэн байх шаардлагатай.</li> </ol> <p>Тендерт оролцогч нь “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-ын 2.4-т заасны дагуу цахим системд бүртгүүлж, нэвтрэх эрх авна.</p>

	<p>Бүртгүүлэх этгээд интернэт хөтөч дээр <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> хаягаар хандаж “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем”-ийн нүүр хуудасны баруун дээд буланд байрлах <b>Бүртгүүлэх-&gt;Нийлүүлэгч</b> цэсийг сонгоно.</p> <p>Нийлүүлэгчийн бүртгүүлэх цэс Нийлүүлэгч нь байгууллага, хувь хүн гэсэн 2 төрөлтэй байх бөгөөд <b>ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ</b> хэсэгт аль тохирохыг сонгож өгнө. Нийлүүлэгчийн төрлөөс хамаарч бөглөх мэдээлэл өөр байх ба холбогдох талбаруудын утгыг бүрэн, зөв оруулаад өргөдөл илгээх үйлдлийг гүйцэтгэнэ.</p> <p>Бүртгүүлэх хүсэлтийн хариу байгууллага бол хариуцсан ажилтны бүртгэлтэй имэйл хаяг, хувь хүн бол өөрийн бүртгэлтэй имэйл хаяг руу тус тус илгээгдэх болохыг анхаарна уу. Цахим системийн бүртгэлийг хянаж, баталгаажуулахад ажлын 3-аас доошгүй хоног зарцуулагддаг болохыг анхаарна уу.</p> <p>2. Тендерт оролцогч тендерийг цахимаар илгээхдээ тоон гарын үсгээр баталгаажуулна.</p> <p>3. Тоон гарын үсгийг МонПасс СА ХХК (цахим хуудас: <a href="http://www.monpass.mn">www.monpass.mn</a>, холбогдох утас: +976 18002535), Тридум кей ХХК (цахим хуудас: <a href="http://www.tridumkey.mn">www.tridumkey.mn</a>, холбогдох утас: +976 70120722) гэсэн гэрчилгээ олгогч байгууллагын аль нэгээс нь авна.</p>
<p><b>ТШЗ 26.1</b></p>	<p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:</p> <p>Огноо: <b>2024 оны 12 дугаар сарын 09-ний өдөр</b></p> <p><b>Цаг: 11 цаг 00 минут</b></p>
<p><b>ТШЗ 26.2</b></p>	<p>Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна.</p> <p>Огноо: <b>2024 оны 12 дугаар сарын 09-ний өдөр</b></p> <p><b>Цаг: 11 цаг 10 минут</b></p> <p>Тендер нээлтэд оролцох боломжтой газрын хаяг: <b>Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын 721 тоот өрөө</b></p>



### **III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА**

(Тус төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолт, бусад холбогдох баримт бичгийг Төрийн Худалдан авах ажиллагааны цахим систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn))-ийн ТЭЗҮ хэсгээс харна уу.)

## ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАРЛАЛ

Огноо:	2024 оны 10 дугаар сарын 03
Тендер шалгаруулалтын төрөл:	Ажил
Тендер шалгаруулалтын нэр:	Их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл “Метро”-г барих төслийн бүтээн байгуулалтын ажил (Улаанбаатар хот)
Тендер шалгаруулалтын дугаар:	НХААГ/20240101236
Нийт төсөвт өртөг:	4,548,375,000,000 төгрөг, үүнээс 2024 онд 333,000,000,000 төгрөг санхүүжигдэнэ.
Тендер шалгаруулалтын арга:	Хоёр үе шаттай нээлттэй тендер шалгаруулалт

1. **Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар** нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага, шалгуур үзүүлэлт хангасан аж ахуй эрхлэгчийг **Их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл “Метро”-г барих төслийн бүтээн байгуулалтын ажил (Улаанбаатар хот)** үзүүлэх тендер ирүүлэхийг урьж байна.
2. Тендер шалгаруулалт нь дараах багцуудаас бүрдэнэ: **“Үгүй”**
3. Тендерийг **2024 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 11 цаг 00 минутаас** өмнө тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар илгээх ба тендерийг **2024 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 11 цаг 10 минутад** нээнэ.
4. Тендерийн хувилбарт саналыг зөвшөөрөх эсэх: **“Зөвшөөрөхгүй”**
5. Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: **“Эрхтэй”**
6. Тендер нь түүнийг нээснээс хойш ажлын 30 ба түүнээс дээш өдрийн хугацаанд хүчинтэй байхаар тендерт заана.
7. Тендерийн баталгаа шаардах эсэх: **“Үгүй”**
8. Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: **“Үгүй”**
9. Тендер шалгаруулалтыг хоёр үе шаттай зохион байгуулж байгаа эсэх: **“Тийм”**
10. Оролцогч цахим системийн үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээх эрхтэй байна.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийг доорх хаягаар хүргүүлж болно.

Нийслэлийн Нутгийн захиргааны төв байр, Б блок 7 давхар,  
23 дугаар хороо, Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 17100  
Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар,  
Утас: 75757807  
[www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)